



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд
нэмэлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.15, 7.1.33, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.3.4, “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл” олгох комиссын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний бичилтэд нэмэлт оруулах байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Ж.Энхзул)-т үүрэг болгосугай.


ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА

142022 01041

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны
өдрийн 47 дугаар тушаалын хавсралт
/41



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ
ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

Улаанбаатар хот

2022 оны 03 дугаар сарын 01

№	Байгууллагын нэр (РД)	Гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Нэмэлт	Хүчинтэй хугацаа
1	Мон тариур ХХК РД-6612709	ҮХ-21/24/0019	Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх	Өөрийн үйлдвэрийн түүхий эд, туслах материалыг импортлох	2024.12.27
2	Гранд эко эхлэл ХХК РД-6606857	ҮХ-21/24/0006	Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх	Өөрийн үйлдвэрийн түүхий эд, туслах материалыг импортлох	2024.08.19